



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 9/112

Хэрлэн сум

Талбайн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж  
авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Газрын хэвллийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны "Журам батлах тухай" 222 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.5.3 дахь заалт, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023 оны А/439 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хийгдэж буй дэд бүтцийн ажлуудын нөлөөгөөр эвдрэлд орсон талбайн нөхөн сэргээлт, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрөлтэй талбайд хийгдсэн нөхөн сэргээлт, эвдэрч орхигдсон талбайд хийгдсэн нөхөн сэргээлт, эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
дарга:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Нарийн бичгийн  
дарга:

Байгаль орчин аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвллий түүний баялгийн ашиглалт, уул уурхай, БОНБҮнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал хариуцсан мэргэжилтэн

Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын  
Газрын удирдлагын хэлтсийн дарга

Тухайн сумын Засаг дарга

Тухайн сумын Татварын байцаагч

Тухайн сумын Газрын даамал

Тухайн сумын Байгаль хамгаалагч, Байгаль орчны мэргэжилтэн

Сумын иргэдийн төлөөлөл

2.

2. Нөхөн сэргээлтийн ажлыг хууль тогтоомжид заасны дагуу хүлээн авч, акт үйлдэн баталгаажуулан дүн мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн даргад даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг ханггуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 06 сарын 29-ний өдрийн А/373 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

